



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 29 өдөр

Дугаар А/328

Чингис хот

Төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд  
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Эмэгтэйчүүдийн зөвлөл төрийн бус байгууллагаас тавьсан хүсэлтийн дагуу, эмэгтэйчүүдэд зориулсан сургалт, арга хэмжээ зохион байгуулах байрыг тохижуулах болон үйл ажиллагааны зардалд 3.000.000 /гурван сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА